**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2020 оны 01 сарын 23 өдөр — Дугаар А/31 — Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Оросын Холбооны Улсын В.А.Алмазовын нэрэмжит Эрүүл мэндийн үндэсний судалгааны төв хооронд 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

141200170

Эрүүл мэндийн сайдын
2020 оны ..01/сарын 31.-ны өдрийн
А/31 дугаар тушаалын хавсралт

# МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог нэр | Харьяалал | Монгол Улсад ажиллах байгууллага | Хамтран ажиллах гадаадын байгууллага | Гэрчилгээний сери/дугаар | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөрлийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Петров Андрей Евгеньевич<br><br>Petrov Andrei | Оросын Холбооны Улс | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Оросын Холбооны Улсын В.А.Алмазовын нэрэмжит Эрүүл мэндийн үндэсний судалгааны төв | ГЭ0002507 | Мэдрэлийн мэс засал судлал | Эмчлэх | 2020.02.07-2020.02.10 /4 хоног/ |